БАТЛАВ:
НИЙСЛЭЛИЙН АВТО ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ИНДРА

# АВТО ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ТЕХНИКИЙН ДААЛГАВАР

Дугаар: ТД2020/017 Улаанбаатар хот

| | | |
|---|---|---|
| 1 | Зураг төсөл боловсруулах үндэслэл | -Нийслэлийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн А/1005 дугаар захирамж<br>-Хот байгуулалт хөгжлийн газрын 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн ГБМЗХ2019/16-10 дугаар албан бичиг |
| 2 | Байршил | Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, Парисын гудамжнаас “The One Residence” орон сууцны цогцолбор байр хүртэлх авто зам |
| 3 | Хөрөнгө оруулалтын эх үүсвэр | Нийслэлийн төсвийн хөрөнгөөр |
| 4 | Авто замын техникийн ангилал, замын зэрэг | Нутаг дэвсгэрийн зам |
| 5 | Газрын бартаалаг, төвөгшил | Трасс сонголтын үеийн болон замын төсөллөлтийн төвөгшлийг БНбД-ээс харах |
| 6 | Замын хучилтын хийц | Хучилтын бүтээцийг тооцоогоор үндэслэнэ |
| 7 | Зураг төсөл зохиох үе шат, хугацаа | 1 үе шаттай 2020 он |
| 8 | Зураг төслийн байгууллага | Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага |
| 9 | Захиалагч байгууллага | Нийслэлийн Авто замын хөгжлийн газар |
| 10 | Зураг төслийн иж бүрдэл | 1. Инженер геодезийн ажлын тайлан<br>2. Инженер геологийн судалгааны ажлын тайлан<br>3. Авто зам, замын байгууламжийн техникийн зураг төсөл<br>4. Тайлбар бичиг (ажлын нэр, тоо хэмжээ, авто зам, замын байгууламжийн зураг төслийн иж бүрдэл, холбогдох захирамж, гэх мэт)<br>5. ИШС-ний холбогдох байгууллагаас тодруулга авах<br>6. Техникийн шаардлага<br>7. Авто замын төсөв / магадлалаар оруулах/ |

11. Онцгой нөхцөл:

- Авто замын зургийг Монгол улсад мөрдөж буй “Авто зам төсөллөх” ЗЗБНбД 22-004-2016, “Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ” БД81-104-02, “Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм“ БНбД 30.01.04, Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль” БД31.101.04, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS 6056:2009, “Авто зам, замын байгууламж болон инженерийн шугам сүлжээний ажлын төсөвт өртгийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн жишиг нормын дагуу тооцох, ЗТХ-ийн Сайдын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 168 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам” болон бусад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох норм дүрмүүдийг үндэслэх
- “Геодези зураг зүйн тухай” хуулийн 6.1.3 дугаар заалт, “Барилга байгууламжийн инженерийн

судалгааны нийтлэг үндэслэл" БНбД 11-07-04-ын II хэсэг инженер геодезийн ажил, "Геодезийн ажил "БНбД 3.01.03-88-д тавигдах шаардлагын дагуу зураг төслийг боловсруулах

- Геодезийн хяналтын инженерээр байр зүйн зураглалыг зураг төслийн төлөвлөлтийн шатанд хянуулж баталгаажуулах
- Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөө, Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага, Улаанбаатар хотын хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөө, Гэр хорооллын дахин төлөвлөлт, тухайн нутаг дэвсгэрт хийгдэх шинээр болон өргөтгөн шинэчлэх авто замын зураг төслийн трасстай уялдуулан зураг төслийг боловсруулах,
- НАЗХГ, ЗХУТ, НГЗБА-тай санал солилцож зөвшилцөх
- Хэмжилт зураглалын ажлыг улсын сүлжээний цэгүүдэд тулгуурлан хийх, авто замын техникийн зураг төсөл боловсруулах
- Хучилтын хийцийг тооцоогоор оновчтой сонгох
- Авто замын зурваст орсон барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд зүйлсийг нарийвчлан гаргах, зургийн шийдлийн дагуу зайлуулах бол тусгах, Мөн замын дагуух үзэгдэх орчинг тооцож,
- Авто замын үндсэн элементүүд болох зорчих хэсэг, явган хүний зам, гадаргуугийн ус зайлуулалах асуудлыг шийдвэрлэх, Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчинг бүрдүүлэх зорилгоор хөдөлгөөн зохион байгуулалтын арга хэмжээ, тоноглол, замын холбогдох байгууламжийг тусгах,
- Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын захиалгаар хийгдэх явган хүний замын ажилтай уялдуулах
- Хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган замын хажууд тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохион байгуулалтын тоноглолыг иж бүрнээр зураг төсөлд тусгах
- Байр зүйн болон өндрийн хэмжилтийг UTM системд хийх
- Зураг төслийг дараах масштабтайгаар боловсруулна. Үүнд:

| | | |
|---|---|---|
| Дэвсгэр зураг | | 1:200 -1:500 |
| Дагуу огтлол | хэвтээ | 1:1000 |
| | босоо | 1:100 |
| Хөндлөн огтлол | | 1:100 |
| Уулзвар, огтлолцол | | 1:500 |
| Бүтэц | | 1:20 |

- Авто замын техникийн зураг төсөлд замын байгуулалт, зай хэмжээ, дагуу огтлол, хөндлөн огтлол, хөдөлгөөн зохион байгуулалтыг төсөллөж, цэгүүдийн координат, зам барилгын ажлын тоо хэмжээг оруулсан байна.
- Тухайн замын үндсэн элементүүдийг ( авто зам, зогсоол, хөдөлгөөн зохион байгуулалтын тэмдэг тэмдэглээ, инженерийн шугам сүлжээ гэх мэт) Layer тус бүрээр нь салгаж Autocad файлаар өгөх.
- Авто замын техникийн зураг төсвийг эх хувь 1ш, хуулбар хувь -3ш / хуулбар хувийг өнгөтөөр хувилж авчрах/ тоон хэлбэрээр / DWG болон PDF / хүлээлгэн өгнө.

**Хянасан:**

НАЗХГ-ын Орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч / Э. Мөнх-Од /

НАЗХГ-ын Бодлого, зохицуулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Энхбаатар/

НАЗХГ-ын Бодлого, зохицуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн /Б.Анхбаяр/

Боловсруулсан:
НАЗХГ-ын Бодлого, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн /Б.Ертис/

НИЙСЛЭЛИЙН АВТО
ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР

| Газрын байршил | Газрын зориулалт |
|---|---|
| Сүхбаатар дүүрэг, 1-р хороо | Авто зам, замын байгууламж |




**Таних тэмдэг**

Төлөвлөж буй авто зам

Хянасан:
НАЗХГ-ын Бодлого зохицуулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ........................./О.Энхбаатар/

НАЗХГ-ын Бодлого зохицуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн ........................./Б.Анхбаяр/

Боловсруулсан:
НАЗХГ-ын Бодлого зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн ........................./Б.Ертис/